



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 78

Есөнбулаг сум

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үйлдвэржилтийг дэмжих ажлын хүрээнд орон нутгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байр бий болгох зорилгоор “Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Зээл олгох салбарын үйлдвэрлэлийн чиглэл”-ийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох зээлийг “Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын дагуу олгох ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

3. Уг тогтоол гарсантай холбогдуулан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 сарын 11-ний өдрийн 42 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА  Т. ГАНЗОРИГ

13.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 18 дугаар сарын 24 өдрийн
18-дугаар тогтоолын 1-дүгээр хавсралт

**АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ,
ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Аймгийн Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйлдвэржилтийг дэмжих зорилт, арга хэмжээний хүрээнд экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин, гарааны бизнес эхлүүлэх болон ажлын байр шинээр бий болгож, нэмэгдүүлэх зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд аймгийн “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан” /цаашид “Дэд сан” гэх/-гаас олгох хөнгөлөлттэй зээл /цаашид “Зээл” гэх/-ийн ерөнхий нөхцөлийг тогтоох, зээл олгох, эргэн төлөхтэй холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Санд ирүүлсэн төслийг хүлээн авч, сонгон шалгаруулж, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий “Төсөл сонгон шалгаруулах хороо” /цаашид “Хороо” гэх/ тус ажиллана.
- 1.3. Зээлийг “Үйлдвэрлэл хөгжүүлэх сан”-гаас санхүүжүүлнэ.
- 1.4. Сангийн орлого, зарлагыг Төрийн сан дахь дансаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд сан Төрийн сангаас гадуур данстай байхыг хориглоно.
- 1.5. Энэ журмын 1.4-т заасан дансанд сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө байршуулахыг хориглоно.
- 1.6. Орон нутгийн хөгжлийн бодлогод тусгагдсан үйлдвэрүүд болон хавсралтад заасан тэргүүлэх чиглэлийн үйлдвэрүүдэд сангаас зээл олгоно.

Хоёр. Сангийн эх үүсвэр, хөнгөлөлттэй зээлийн нөхцөл

- 2.1. Зээлийн эх үүсвэр нь орон нутгийн төсөв болон хуульд заасан бусад эх үүсвэрээс бүрдэнэ.
- 2.2. Сангаас олгосон зээлийн хүүгийн орлого
- 2.3. Хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги
- 2.4. Зээлийн хүүгийн хэмжээ нь жилд 3 хувь байна (Энэ нь өмнөх жилүүдэд байгуулсан зээлийн гэрээнд заасан хүүгийн хэмжээг өөрчлөх үндэслэл болохгүй.)
- 2.5. Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0,5 хувиар алданги төлнө. Алдангийн хэмжээг Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана.
- 2.6. Хөнгөлөлттэй зээл нь 3 жилийн хугацаатай, үндсэн зээлээс чөлөөлөгдөх хугацаа нь 6 сар байна.
- 2.7. Зээлийг зориулалтын дагуу зарцуулан тогтвортой үйл ажиллагаа явуулж буй зээлдэгчийн зээлийн гэрээний хугацааг шаардлагатай тохиолдолд үргэлжлүүлэн 2 жил хүртэлх хугацаагаар сунгаж болно.
- 2.8. Зээлийн эх үүсвэрийг Үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд төвлөрүүлнэ.
- 2.9. Санхүүжилтийг зөвхөн төгрөгөөр олгоно.
- 2.10. Нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ 30,0-80,0 сая төгрөг байна.
- 2.11. Санд төлөх зээлийн үлдэгдэлтэй, зээлийг төлж дууссан боловч зориулалт бусаар ашигласан нь тогтоогдсон, банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоонд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл, эсхүл муу зээлийн түүхтэй, Татварын алба, Нийгмийн даатгал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад өр төлбөртэй зээл хүсэгчийг зээлд хамруулахгүй.

Гурав. Төсөл сонгон шалгаруулах хорооны чиг үүрэг

- 3.1. Хороо нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн таван хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.2. Төсөл сонгон шалгаруулах хороог аймгийн Засаг даргын захирамжаар байгуулна.

3.3. Хорооны даргаар аймгийн Засаг даргын орлогч, нарийн бичгийн даргаар тухайн салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллана.

3.4. Хорооны бүрэлдэхүүнд төрийн байгууллагыг төлөөлж санхүү эдийн засаг, хууль, хөдөө аж ахуйн чиглэлийн албан тушаалтан байх бөгөөд төрийн бус байгууллагын нэг төлөөллийг оролцуулна.

3.5. Хороо хуралдааны зарчмаар шийдвэрээ гаргах ба хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нь төсөл сонгон шалгаруулах хуралд саналын нэг эрхтэйгээр оролцоно.

3.6. Хорооны гишүүд бүрэн ирснээр хурал хүчинтэйд тооцогдох ба тэмдэглэл хөтөлж, олонхийн саналаар шийдвэр гаргана.

3.7. Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

3.8. Жижиг, дунд үйлдвэрийн талаар баримталж байгаа төрийн бодлого, шийдвэрт нийцсэн, энэ журмын 4-р хэсэгт заасан шаардлагыг хангасан төслийг хорооны хурлаар хэлэлцэнэ.

3.9. Хорооны гишүүн нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, хувийн ашиг сонирхолд нөлөөлөхүйц шийдвэр гаргах тохиолдолд хуралд оролцохоос татгалзаж, татгалзах хүсэлтээ бичгээр хорооны даргад гаргана.

3.10. Ажил, үүргийн хуваарийн дагуу Хорооны үйл ажиллагаанд оролцогч төрийн байгууллагын ажилтан, албан тушаалтан, төрийн бус байгууллагын төлөөлөл нь бизнесийн нууцыг бусдад мэдээлэх, буруу үнэлгээ хийх, бусдад давуу байдал бий болгохыг хориглоно. Хорооны гишүүн үнэн зөв үнэлгээ хийгээгүйгээс зээлийг эрсдэлд оруулахгүй байх, хууль, журам зөрчихгүй байх үүрэгтэй.

3.11. Төсөл сонгон шалгаруулах хорооноос үнэлсэн төслүүдийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Зээл хүсэгчийн төсөлд тавигдах шаардлага

4.1. Зээл хүсэгчийн ирүүлэх төсөл нь төсөл хэрэгжүүлэгч, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэл, зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо, дүгнэлт, хавсралт гэсэн хэсгээс бүрдсэн байна.

4.2. Тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн 30-иас доошгүй хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах эхлэл тавигдсан байна.

4.3. Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэлд дараахь зүйлийг тусгана:

- 4.3.1 Төслийн товч агуулга;
- 4.3.2 Хуулийн этгээдийн нэр;
- 4.3.3 Үйлдвэрийн байршил;
- 4.3.4 Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, түүнээс өөрийн оруулах хөрөнгийн хэмжээ /нотлох баримтын хамт/
- 4.3.5 Үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр, төрөл;
- 4.3.6 Жилийн эргэлт, борлуулалт
- 4.3.7 Одоогийн эрхэлж байгаа бизнесийн талаарх мэдээлэл.

4.4 Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаарх мэдээлэлд дараах зүйлийг тусгана:

- 4.4.1 Үйлдвэрлэлийн технологийн ажиллагаа;
- 4.4.2 Түүхий эдийн чанарын үзүүлэлт;
- 4.4.3 Түүхий эдийн нөөц;
- 4.4.4 Үйлдвэрлэлийн хүчин чадал.

4.5 Удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын талаарх мэдээлэлд дараахь зүйлийг тусгана:

- 4.5.1 Удирдлагын бүтэц, орон тоо;
- 4.5.2 Ажиллагсдын мэргэжил, мэргэшлийн ур чадвар;
- 4.5.3 Шинээр бий болгох ажлын байрны тоо, аймаг орон нутгийн бүртгэлтэй ажилгүй иргэдээс авч ажиллуулах хүний тоо.

4.6 Зах зээлийн судалгаанд дараахь мэдээллийг тусгана:

- 4.6.1 Зах зээлийн төлөв байдал /SWOT шинжилгээ/;
- 4.6.2 Хэрэглэгчдийн тодорхойлолт.

4.7 Эдийн засгийн тооцоонд дараахь мэдээллийг тусгана:

- 4.7.1 Үндсэн үйлдвэрлэл, нийт орлого;
- 4.7.2 Борлуулалтын орлогын тооцоо;
- 4.7.3 Үйлдвэрлэлийн зардлын тооцоо;
- 4.7.4 Бүтээгдэхүүний өртгийн тооцоо;
- 4.7.5 Төлөвлөж байгаа борлуулалтын төлөвлөгөө;
- 4.7.6 Үйлдвэрлэлийн үр ашгийн тооцоо;
- 4.7.7 Төслийн өгөөж, өртгийн тооцоо;
- 4.7.8 Төслийн эрсдлийн удирдлагын тооцоо, даатгалд хамрагдах тооцоо;
- 4.7.9 Байгаль орчинд ээлтэй болон хор хөнөөлгүй, үйлдвэрлэл явуулах тооцоо.

4.8 Дүгнэлтэд энэ журмын 4.4-4.7-д заасан тооцоо судалгаанд үндэслэн төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн, эрсдэл зэргийг тооцоолсон мэдээллийг тусгана.

4.9 Төсөлд дараах материалыг хавсаргана:

- 4.9.1 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
- 4.9.2 Хуулийн этгээдийн захирлын баримт бичгийн хуулбар, сум, хорооны тодорхойлолт;
- 4.9.3 Тоног төхөөрөмжийн жагсаалт, зураг;
- 4.9.4 Зээлийн эргэн төлөлтийн график;
- 4.9.5 Барьцаа эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ /хуулбар/;
- 4.9.6 Үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл, зураг;
- 4.9.7 Зээлийн өрийн хэвийн үлдэгдэлтэй бол уг зээлтэй холбоотой баримт /зээлийн гэрээ, зээлийн дансны хуулга, тодорхойлолт, зээлийн зарцуулалтын тооцоо/;
- 4.9.8 Санхүүгийн тайлан сүүлийн /2 жил/;
- 4.9.9 Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн талаарх мэдээ.

Тав. Сонгон шалгаруулалт зарлах, төсөл хүлээн авах, ил тод байдал

5.1. Төсөл сонгон шалгаруулах зар болон төсөл хүлээн авах хугацаа, холбогдох мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх үүргийг хорооны нарийн бичгийн дарга хариуцна.

5.2. Хорооны нарийн бичгийн дарга санхүүжилт хүссэн төслийг хүлээн авч нягтлан төслийн бүрдэл, тооцоо, дүгнэлтийг шалгаж, үнэлгээ өгч, шаардлага хангасан төслийг Хорооны хуралд танилцуулах бэлтгэлийг хангана.

5.3. Хорооны нарийн бичгийн дарга шалгараагүй болон шаардлага хангаагүй төслийг холбогдох тайлбарын хамт хорооны хурлын шийдвэр гарснаас хойш ажлын

7-15 хоногт багтаан төсөл ирүүлсэн хуулийн этгээдэд албан бичгээр буцаана.

5.4. Сан нь төсөл хүлээн авах хугацаа зарлагдахаас бусад үед төсөл хүлээн авахгүй.

Зургаа. Төсөл сонгон шалгаруулах, санхүүжүүлэх

6.1. Хорооны хурлаар шалгарсан төслийн жагсаалт, хурлаас гаргасан шийдвэрийг хорооны дарга баталгаажуулан ажлын 5 хоногт багтаан аймгийн Засаг даргад танилцуулна.

6.2. Төсөл сонгон шалгаруулах хорооноос шалгаруулсан төслийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид хэлэлцэж, ажлын 3 хоногт багтаан шийдвэр гаргана.

6.3. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг дарга зээлийн гэрээ байгуулан санхүүжилтийг олгоно.

Долоо. Хяналт шинжилгээ хийх, тайлагнах

7.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь зээлийн гэрээний биелэлт, хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгжийн төслийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэгтэй.

7.2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайланг нэгтгэн тухай бүр аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан үр дүнг тооцон ажиллана.

7.3. Төслийн хэрэгжилтийн явц, үр дүн болон зээлийн эргэн төлөлтөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад илэрсэн зөрчил, дутагдлыг нэн даруй арилгуулах арга хэмжээ авна.

7.4. Зээлийг зориулалт бусаар ашигласан, хууль, журам зөрчиж олгосон нь хяналт, шалгалтын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд тухайн өдрөөс эхлэн уг зээлийг тухайн үеийн арилжааны банкны зээл рүү шилжүүлэх арга хэмжээ авч санд буцаан төвлөрүүлнэ.

7.5. Бодлогын зээлийг зориулалт бусаар ашигласан нь тогтоогдсон тохиолдолд зээлийн гэрээг цуцлах ажиллагаа хийгдэнэ.


7.6. Зээлийг зориулалтын бусаар ашигласныг үнэн зөв тогтоолгүйгээр энэхүү журмын 7.3, 7.4, 7.5-д заасан арга хэмжээг аваагүй эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

Найм. Мэдээ, тайлан гаргах

8.1. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн тайлан, мэдээ, зээлдэгчийн үйл ажиллагааны талаарх судалгааг хорооны нарийн бичгийн дарга улирал бүр нэгтгэн гаргаж, дараа сарын 05-ны өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулна.

17.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 18 дугаар сарын 24 өдрийн
78.-дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



ЗЭЭЛ ОЛГОХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

- Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр
- Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр
- Хүнсний ногоо боловсруулах үйлдвэр
- Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр
- Улаан хальст сармис, суль, цульхир, арвайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Арьс шир боловсруулах үйлдвэр
- Ноос боловсруулах үйлдвэр
- Ноолуур боловсруулах үйлдвэр
- Туслах аж ахуй /гахай, шувууны аж ахуй/
- Эрчим хүчний чиглэлийн үйлдвэр, үйлчилгээ
- Эрчимжсэн мал аж ахуй
- Хог хаягдалыг дахин боловсруулах үйлдвэр
- Газар тариалан
- Хүнсний үйлдвэр
- 4 улирлын хүлэмжийн аж ахуй
- Цементийн үйлдвэр
- Үйлчилгээ /худалдаа үйлчилгээний битүү зах, кино театр гэх мэт/
- Будгийн үйлдвэр
- Шохойн үйлдвэр
- Хөөсөнцөрийн үйлдвэр
- Чулуу бутлах болон боловсруулах үйлдвэр
- Бусад

-оОо-